

“ЧҮНХЯНГ БҮСГҮЙН ДОМОГ” ЗОХИОЛЫН ОРЧУУЛГЫН ХЭЛ НАЙРУУЛГЫН ТУХАЙД

Ц. Оюунгэрэл¹⁸⁹

Товч утга: Орчуулагч Д.Сайнбилэгтийн орчуулсан “Чүнхянг бүсгүйн домог” нь солонгосын утга зохиолын шилдэг төлөөлөл бөгөөд хэн бүхний мэдэх, тэр бүү хэл сурах бичигт зайлшгүй судлах зохиолын тоонд орсон бүтээл юм. Эртний хятадын сонгодог сургаал, шүлэглэл ихтэй, нэр томъёо ихтэй энэхүү зохиолыг монгол хэлнээ орчуулсан нь орчуулагчийн нөр их хөдөлмөр билээ. Зохиолын гол дүрийн үйл хөдлөл, байр байдал, байгаль орчны дүрслэл нь монгол хэлнээ яруу тансаг буусан байдаг. Энэ нь орчуулагчийн гадаад хэлний ур чадвар төдийгүй эх хэлний мэдлэг, найруулгын чадвар бузгай болохыг илтгэх төдийгүй монгол сонгодог бичгийн хэлээр найруулан бичсэн нь орчуулгын хэл найруулгыг тэр хэмжээгээр яруу тансаг болгожээ. Шүлэглэсэн хэлбэрийн толгой мөр холболт, хүндэтгэлийн үгийн зохистой хэрэглээ, хоршоо үгийн найрлага зэргийг чадамгай ашигласан нь уг бүтээлийн үнэ цэнийг улам нэмэгдүүлж байна.

Түлхүүр үг: Солонгосын уран зохиол, Чүнхянг бүсгүйн домог, орчуулгын хэл найруулга, хүндэтгэлийн үг, хоршоо үг, шүлэглэсэн хэлбэр

0. Оршил

Монголчууд эртнээс гадаад улсын утга зохиолыг төрөлх хэлнээ орчуулан уншиж, танилцаар иржээ. Олон орны ардын үлгэр домог төдийгүй роман, тууж өгүүллэгийг эх хэл дээрээ уншсаар ирсэн нь гүүш орчуулагчдын ач гавъяа юм. Ардчилсан хувьсгалаас өмнө ихэвчлэн орос зөвлөлтийн зохиолчдын зохиолын орчуулга юмуу өөр орны зохиолыг орос хэлнээс дам орчуулсан зохиол байлаа.

Орчуулга гэдэг амар ажил биш бөгөөд ялангуяа уран зохиолын орчуулгыг аль нэгэн гадаад хэлийг гаргуун сайн эзэмшсэн гээд хэн бүхний хийх зүйл биш бөлгөө. Гадаад хэлний мэдлэгээс гадна эх хэлээ сайн мэддэг, монголоор сэтгэж, монгол хэлээр бичиж найруулах эрдэм чадварт боловсорсон байх хэрэгтэй.

Манай монголчууд дорны уран зохиолтой эртнээс танилцаж, социалист нийгмийн үед БНАСАУ-тай харилцаатай байж, зарим нэг зохиол, үлгэр домгийг орчуулж ирсэн хэдий ч, өмнөд солонгосын утга зохиол 1990-ээд оноос хойш уншигчдын хүртээл болжээ. Энэ үеэс солонгосын шилдэг өгүүллэг, шилдэг шүлгийг монгол хэлнээ орчуулах ажил ид өрнөж, олон орчуулагчдын бүтээлүүд төрөн гарчээ. Түүний дотроос солонгосын пансури буюу дуулалт жүжгийн нэгэн томоохон төлөөлөл болох “Чүнхянг бүсгүйн домог” зохиол доктор Д.Сайнбилэгтийн орчуулснаар монголын ард түмэнд хүрсэн байна. Уг

¹⁸⁹ ОУУБИС-ийн багш

орчуулгын бүтээлийн хэл найруулгын онцлог, уламжлалыг хадгалсан байдлын тухай онцлон тэмдэглэж, яруу тансаг орчуулгын чанар чансааг тодруулан гаргах нь уг өгүүллийн гол зорилго юм. Монгол уншигчдад хүрсэн энэхүү орчуулгын бүтээлийг солонгосын уран зохиолыг шимтэн уншигч хэн бүхэн, судлан шинжлэгч эрдэмтэн судлаачдад орчуулгын сайн талыг илрүүлэн гаргаснаар бидний үед нэгэн орчуулагч, солонгосын нэгэн сайхан зохиол орчуулагдсаныг тэдний сонорт хүргэнэ. Орчуулгын зохиолын хэл найруулга яруу тансаг, энгийн эрхэм байснаар тухайн улсын уран зохиолыг өөр үндэстэнд шууд хүргэх дөт зам болдог билээ.

1. Солонгосын уран зохиолын тухай

Солонгосын эртний уран зохиол нь солонгосын хойгт хүн суурьшиж эхэлсэн үеэс эхлэлтэй гэж үздэг ба амнаас ам дамжин хэлэгдэж байсан үлгэр домог бичгээр үлдэн солонгосын утга зохиолын санг баяжуулжээ. Тан улсын үед Чөнги буюу “хачин жигтэй явдлыг өгүүлэх нь” гэсэн утга бүхий бичвэрийн хэлбэр ихэд дэлгэрч, Корё улсын дээд зиндааныхан аман үлгэр домогтой уялдуулан зохиосноор үргэлжилсэн үгийн зохиол бий болсон байна. Тиймээс эхэн үеийн уран зохиолын бүтээлүүдэд домог үлгэрийн шинж ихээхэн байдаг байсан ба ид оргил үе нь 17-р зуун юм. Энэ үед Чүсэнжөн, Чойчөгжөн, Үниөнжөн зэрэг бүтээл гарсан ба ханз үсгээр бичсэн, хятад маягийн шүлэглэл ихтэй зэрэг нь уран зохиолын гол хэв шинж болно. Дайн тулаантай, үймээн самуунтай үе байсан болохоор зохиолын гол баатрууд уйтгар гунигаасаа салахын тулд бодит бус хий хоосон ертөнцөөр аялна. Зохиолын төгсгөл нь гол баатар сураггүй болох юмуу үхэх зэргээр дүрслэгддэг. Бодит амьдралд байхгүй тэр эрх чөлөөг хий хоосон, зүүдний ертөнцөд болж буйгаар дүрслэн өгүүлсэн нь уран зохиолын ийм төрлийг үүсгэсэн байдаг.

Ийнхүү Шилла, Горё улсын үеэс өнөөг хүртэл солонгосын уран зохиол өөрийн гэсэн түүхэн үе, үйл явцыг туулан ирсэн бөгөөд солонгосын хойгийн өмнөд хэсэгт орших олон сая хүн амтай БНСУ-ын уран зохиол өөрийн гэсэн хэв маяг, үндэсний уламжлалтай болон хөгжжээ.

2. “Чүнхянг бүсгүйн домог” зохиолын тухай

Солонгосын пансури буюу солонгос үндэсний дуулалт жүжгийн аман хэлбэрээс үүссэн “Чүнхянгийн дуулал” нэртэй уг зохиол нь 17-р зууны эхэн үеэс бичмэл хувилбараар дэлгэрч, хэлбэр агуулгын хувьд баяжин нэмэгдсээр иржээ. Зохиолын ерөнхий нэр нь “Чүнхянг бүсгүйн домог” бөгөөд олон хувилбартай. Эдгээр хувилбараас орчуулагч Д.Сайнбилэгт “Бат журамт Чүнхянг бүсгүйн дуулал”-ыг монгол хэлээр буулгажээ. Уг хувилбар нь 84 бараар хэвлэгдэж, эрдэмтэн судлаачдын хамгийн их судалсан зохиол юм.

Зохиолын гол онцлог нь Жусоны улсын нийгмийн амьдрал, хүмүүсийн төлөв байдлыг уран сайхны аргаар яруу тансаг дүрслэн үзүүлжээ. Тухайн нийгмийн үе

нь дундад зууны сүүл бөгөөд дээд, доод угсааны эрэгтэй, эмэгтэй хоёрын хайр дурлалыг сэргүүлэн гаргасан нь түгээмэл шинж юм.

Агуулга нь, Чусон улс Сүгжон хааны үе дэх Намвөн хотын захирагчийн хүү И Монгрюун, дууч эмийн охин Сөн Чүнхянг хоёрын хайрын тухай түүх бөгөөд нийгмийн давхаргын ялгааг үл харгалзан бие биедээ сэтгэлтэй болон улмаар эхнэр, нөхөр хэмээгдэнэ. Залуугийн эцэг хэргэм зэрэг ахин Сөүл явах болсноор хайртай хоёр хагацан салж, бүсгүйн хувьд зовлонт өдрүүд эхэлнэ. Намвөн хотод шинээр томилогдсон Биен Хагдо захирагч Чүнхянг бүсгүйг өөрийн эрхэнд оруулах гэсэн боловч, бүсгүй эр нөхөртөө үнэнч гэдгээ харуулж, бат журмыг сахина хэмээснээр төрд тэрсэлсэн ялд унаж, торлогдон шийтгүүлж, шоронд ордог. Бүсгүйн амь нас дээсэн дөрөөн дээр ирсэн тэр мөчид И Монгрюун байцаагч сайд болон эргэн ирснээр аврагдана. Дээрэнгүй, эрх мэдлээ урвуулан ашиглагч Биен Хагдо захирагчийг буулган, хайртай бүсгүйгээ авран, удалгүй хуримлан сууснаар амар сайхандаа жаргана.

Чүнхянг бүсгүйн тухай энэхүү зохиол нь уран зохиолын олон төрлийг хамарч, ард олны хүсэл эрмэлзлэлийг харуулж чадсан зохиол тул одоо ч солонгосын ард түмний дунд дуу бүжиг, дуулалт жүжиг, кино, дуурь болон амилсаар байгаа ба дунд сургуулийн сурах бичигт зайлшгүй сурах хичээлийн нэгд тооцогдож байдаг тул олонд танил болсон бүтээл билээ. Мөн уг зохиолын үйл явдал өрнөдөг газар болох Намвөн хотод жил бүр Чүнхянг бүсгүйн нэрээр Чүнхянг наадам зохиогддог.

3. Орчуулагчийн тухай

Хэрэйдийн сайн эрс овогт Дашдоржийн Сайнбилэгт орчуулагч нь Улаанбаатар хотын унаган иргэн. МУИС-ийн ОУХДС-ийн солонгос судлалын анги төгсөж, 1999 онд магистрын зэрэг хамгаалжээ. Тэрээр төгсмөгцөө “Баярт мэдээ” хэвлэлийн газарт орчуулагчаар ажлын гараагаа эхэлж байсан нь түүний бас нэгэн давуу тал боловуу. 1996 оноос МУИС-ийн ГХСС-д багшилж эхэлсэн нь боловсролын байгууллагад нэгэн эрдэмтэн судлаач төрөх эхлэлийг тавьжээ. 2005 онд БНСУ-ын Сөүлийн Их Сургуулийн боловсрол судлалын докторын зэрэг хамгаалж эдүгээг хүртэл МУИС-даа ажилласаар байна. Солонгос хэлээр мэргэшиж, солонгос хэлний багшаар ажиллангаа аман болон бичгийн орчуулгын чамбай мэргэжилтэн болсон юм. Солонгосын уран зохиолын шилдэг төлөөлөл болох “Чүнхянг бүсгүйн домог” бүтээлийг эх хэлнээ уран яруу, тансаг сайхнаар орчуулсан нь монголын орчин үеийн орчуулагчдын эгнээнд нэгэн сайн орчуулагч төрөн гарсан хэмээн үзэж байна.

4. “Чүнхянг бүсгүйн домог” хэмээх зохиолын орчуулгын хэл найруулгын онцлог

Уран зохиолын орчуулга аливаа улс үндэстний соёл, урлагийг бусад улс оронд таниулахад үлэмж их нөлөө үзүүлсээр ирсэн түүх жамтай. Үндэстнүүд

хоорондоо орчуулгаар л соёлын холбоо барьж байсан цаг хүн төрөлхтөний түүхэнд байжээ.

Аль ч улсын түүхэнд ном зохиол орчуулагсад нь гол төлөв эрдэмтэн, зохиолчид байсан бөгөөд тэд өөрийн орны хүн ардад харь орны амьдрал, аж төрөл, соёлын ололтыг танилцуулахын тулд аль сайн ном, зохиолыг нь шилж төрөлх хэлэндээ орчуулдаг байв. Уран зохиол орчуулахад эх зохиолын хэлийг гойд сайн мэдэхээс гадна уг уран зохиолын гоо сайхан чанарыг нь нэвтэрхий ухаарсан байх зайлшгүй шаардлагатай билээ. Уран зохиолын баатруудын зан төрх, дүр байдал, түүний уран хэлхээ холбоос, хэл найруулгыг махчлан орчуулаад байвал уг зохиол уран сайхан чанараа алдаж зөвхөн нүцгэн санаа үлдэнэ.

Үг гэдэг өдий төдий олон салаа утга санаа илэрхийлж чаддаг учир төрөлх хэлнийхээ яг тохирсон үг хэллэг олж эх зохиолын дүр зургийг буулгах нь орчуулагч хүнийг арга буюу бодох, эрж хайх, бүтээх ажил руу татаж оруулдаг. Орчуулга хийхэд үгийг онож орчуулах, үгийн олон салаа утгыг сайн анхаарах, эх зохиолын хэл найруулгын онцлог, зохиогчийн хэл найруулгын өвөрмөц шинж, зохиолын дүр, түүний орчин хүрээ, түүхэн үетэй уялдуулж үг сонгон найруулсан байдал зэрэг нь онцгой ач холбогдолтой.

“Чүнхянг бүсгүйн домог” зохиолын орчуулгын хэл найруулгыг ажиглаж үзэхэд дараах онцлогтой байна.

Эртний монгол хэлний бичгийн хэлний нөхцөл дагаврыг олонтаа хэрэглэсэн нь найруулгыг улам тансаг сайхан болгожээ. Ялангуяа орчин цагийн монгол хэлний найруулгад төдийлөн бичигддэггүй монгол бичгийн дагавар, нөхцөлийн хэлбэрийг өгүүлбэр бүрт шигтгэн оруулж өгсөн нь уг зохиол нь солонгосын эртний зохиол төдийгүй яруу тансаг найруулга бүхий бүтээл юм гэдгийг тод томруун харуулжээ. Тухайлбал, -хуйд, -хүйд, ахуйд, -ваас, -вээс, атал, агаад, -руун,-рүүн, -хүл, -юугаа, -юүгээ, аваас, -муй, -мүй холбоо үг, нөхцөл зэргээс гадна “-дор, бээр, -лүгээ, -лугаа, -наа” гэх мэт тийн ялгалын нөхцөлийг монгол бичгийн хэлнийхээс оруулсан байна.

“Хөөн явуулсан дор...”, “Хайрхан уулын суваргад очиж мөргөн гуйваас...”, “...урагшаа Жири уул сүглийн харагдах агаад уул шугуйн дундуур урсах Юучон гол хөх судал татан сунан урссаар зүүн өмнөд зүг рүү алсран одохуйд...”, “...Яо Шүнь хаадын үе лүгээ адил ажээ.”, “... арш лугаа адил сайхан төрхтэй агаад...”

Солонгос хэлэнд хүндэтгэлийн үг хэллэг нилээд хөгжсөн бөгөөд энэхүү онцлогийг ч орчуулагч бүтээлдээ сайн тусгажээ. Хүндэтгэвэл зохих хүнтэй ярьж буй ярианы хэллэг бүрт монгол хэлний хүндэтгэлийн үг хэллэгийг зөв зохистой оруулсан байна. Үүнд:

“Та таалан соёрхоно уу.”, “Эхлээд эцэгтээ бараалхан төлөв номхоноор айлтгаруун...”, “Эрхэм дээдэс та манай муу овоохойд морилон ирсэнд...” гэх мэт.

Шүлэглэн холбосон биш боловч, юм үзэгдэл, хөдөлгөөнийг илэрхийлэхдээ мөр холбон орчуулсан байна.

“...угалзан хээтэй ухаа ягаан арьсан гутлаа суга татан тайлж...”

“...хавар цагт халин нисэх хараацай лугаа адил ажээ” гэх мэт.

Шүлгийн хэм хэмнэлийг алдахгүй, толгой холбон орчуулжээ. Тухайлбал,

“Улсын үр тарианаас хулгай хийгээгүй атал

Учир юунд ийм хүнд ял тулган зовооном

Хүмүүний амийг бүрэлгээгүй атал

Хүзүүнд минь дөнгө, гарт минь гав торлодог нь юув...”

Монгол хэлний хоршоо үгийг чадварлаг ашиглан найруулга, хэм хэмнэлийг тод томруун гаргажээ. Жишуулбал,

“Хот даяар ажин түжин үгүй амаржиж...”, “...хүүхдийн цовоо цолгин дуу чих дэлдэн, дүүрэн жаргалтай түвшин амгалан сууцгаах нь...”, “Мянгантаа мөргөн түмэнтээ гуйсанд...”

Мөн монгол хэлний ардын уламжлалт зүйрлэл үг хэллэгийг оновчтой ашигласан нь орчуулгыг монгол уншигчдад хүрэхүйц яруу тунгалаг илэрхийлэл болжээ хэмээн үзэж байна. Жишээлбэл,

“Нэртэй айлын зүстэй хүү...”, “...хар үс чинь буурал болохын цагт...”, “дээр тэнгэр хол доор газар хатуу болохоор...” гэх мэт.

Хүний дүр төрх, үйл хөдлөл, шинж байдлыг толгой холбон, уран яруу дүрслэн үзүүлсэн байна. Тухайлбал,

“Хашийн тунгалаг царай нь үүлэн чөлөөгөөр үзэгдэх гэрэлт саран адил, үл ялиг ангайсан улаахан уруул нь усанд дэлбээгээ нээсэн бөлбөө цэцэг мэт болой.” (Чүнхянг бүсгүй)

“...хатан зоригт олноос онцгой шилдэг эр байлаа. Идэр залуудаа их гавьяа байгуулах шинж бүрдсэн өргөн сайхан магнайтай, улсаа хамгаалж үнэнчээр зүтгэх түшмэлийн шинж тодорсон царайлаг төрхтэй...” (И Монгрюун залуу ноёнтон)

“Эрдэм номд сүрхий, эрэлхэг дайчин чанартай, элдэв наадамд дуртай, эмс хүүхэнд хорхойтой нэгэн бөгөөд...”(Намвөний шинэ захирагч Биен Хагдо)

Байгалийн зураглал ч мөн яруу тансаг болжээ. Жишээлбэл,

“Хүрхрээний захаар цэцэгс цомирлогоо дэлгээд, өндөр гоолиг нарс битүү ургасан энэ улирал болбоос модны сүүдэр цэцгийн анхилам үнэрт жаргах цаг мөн ажгуу. Гавар, зандан, цээнийн цэцэг, тоорын үнэрт согтуурсан уулс сунагар голын хөх долгионд умбан шумбажээ” Энэ мэт жишээ олон бий.

Дүгнэлт

Чусон улсын үеийн эгэл жирийн амьдрал, эрхэм дээдсийн ном бичгийн эрдэм, Чүнхянг бүсгүйн аж төрлийн тухай уран аргаар яруу дүрслэн бичсэн энэ зохиолд эртний ба дундад эртний хятадын сонгодог сургаал, яруу найрагчдын гүн ухааны зохиолоос ишлэсэн шүлэг дууллын мөр, бадаг бишгүй байдаг бөгөөд энэ бүхнийг эх хэлнээ тансаг сайхан буулгасан байна. Уг зохиолд гарч буй хятадын эртний мэргэдийн сургаал үг, цэцэн мэргэн хэллэг, хүний нэр, газар орны нэр, түүх шастирийн оноосон нэр, нэр томъёо зэргийг оноон нэршсэн, хэвшсэн сонгодог нэр томъёоллоор нь хөдөлшгүй оноон нэрлэсэн нь орчуулгын зохиолын бас нэгэн давуу тал болно.

Орчуулгын зохиолыг уншаад, монгол хэлнээ буулгасан хэл найруулгыг ажин үзсэн нь энэ бөгөөд солонгос эхтэй нь тулган үзэж, бас бус алдаа оноо байгааг үгүйсгэх аргагүй юм. Хэдий тийм ч энэхүү бүтээлийг орчуулгын хэл найруулгын хэмийг алдагдуулалгүй эх хэлнээ яруу тансаг, уран цэцэн буулгасан нь цаашид судлаачид, эрдэмтдийн зайлшгүй судлах шаардлагатай ховор судлагдахуун болжээ хэмээн үзэж байна. С.Бадраа гуай “уран зохиолын орчуулга бол зөвхөн гар хурууны үзүүрээр хийдэг ажил бусаар үл барам, нинжин сэтгэлийг шаарддаг” гэснийг тунгаан бодоход илүүдэхгүй биз ээ.

Ашигласан материал

Гадаад хүнд зориулсан солонгосын уран зохиолын түүх, И Сөни ба бусад, Сөүл, 2012, Солонгосын соёл хэвлэлийн газар

Орчуулах эрдэм, Монголын зохиолчдын эвлэл, Улаанбаатар, 1972, Хэвлэлийн Газар

Сайнбилэгт.Д., Чүнхянг бүсгүйн домог, Улаанбаатар, 2006, Мөнхийн үсэг

Resume

The main character in literary activity, building, environmental and graphics has fallen into Mongolian poetry luxury. This is an interpreter for foreign language skills as well as knowledge of the original language and wording does not have a decent ability as well as Mongolian classical written language directed translation of the written language, made luxurious by the same amount. Poetic form of the head line connection, the proper use of the word honor, cooperative component of the word of skill used, which increases the value of the work.